

МОНГОЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ДҮРЭМ

/шинэчилсэн найруулга/

1 дүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

1.1. Монголын хохирол үнэлэгчдийн холбоо /цаашид “Холбоо” гэх/ нь “Хөрөнгийн үнэлгээний тухай хууль”-ийн 25-д заасан байгууллага байх бөгөөд тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгийн үнэлгээчин болон даатгалын хохирол үнэлэгчдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, тэдгээрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий гүйшүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага мөн.

1.2. Холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Албан журмын даатгалтай холбогдох бусад хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, эрхийн акт, энэ дүрмийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

1.3. Холбооны үйл ажиллагаа нь Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд зааснаас бусад харилцаа Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулагдана.

1.4. Холбооны албан ёсны оноосон нэр “МОНГОЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧДИЙН ХОЛБОО”, англи хэл дээр “MONGOLIAN ASSOCIATION OF LOSS ADJUSTERS” гэнэ.

1.5. Холбоо нь Бүх гишүүдийн хурлаас баталсан бэлэг тэмдэг, нэрэмжит шагналтай байх бөгөөд тамга тэмдэг, цахим хаяг, албан хэргийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.6. Холбоо нь 2013 оны 6 дугаар сарын 17-ний өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацаа нь Монгол улсын хуулиар хязгаарлагдана.

2 дугаар зүйл. Холбооны зорилго, үйл ажиллагааны чиглэл

2.1. Холбооны зорилго нь Монгол улсад хөрөнгийн болон даатгалын хохирол үнэлгээний үйл ажиллагааг төлөвшүүлэх, даатгалын зах зээлийн тогтвортой хөгжлийг хангахад үнэлгээний компаниудын үүрэг, оролцоог дээшлүүлэх, даатгагчдын болон даатгуулагчдын хоорондын итгэлцлийг бэхжүүлэх, гишүүдийн нэр хүнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор хуульд заасан үйл ажиллагаа явуулахад оршино.

2.2. Холбоо нь энэ дүрмийн 2.1-д заасан зорилгын хүрээнд холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна:

- 2.2.1. Хөрөнгийн болон даатгалын хохирол үнэлгээний эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр мэргэжлийн бусад байгууллага болон төрийн эрх бүхий байгууллагад санал хүргүүлэх, хэлэлцүүлгийн шатанд болон шийдвэр гаргахад оролцох, тэдэнтэй хамтран ажиллах;
- 2.2.2. Гишүүдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах, энэ тухай асуудлаар холбогдох байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх;
- 2.2.3. Хөрөнгийн үнэлгээний болон даатгалын хохирол үнэлгээний үндэсний стандартыг боловсруулж мөрдүүлэх
- 2.2.4. Хохирлын үнэлгээний үйл ажиллагааны чиглэлээр ажиллаж буй гишүүд болон харилцаж буй төрийн байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчдод хохирлын үнэлгээний чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах, тэмдэг, сертификат, гэрчилгээ олгох;
- 2.2.5. Хөрөнгийн үнэлгээний болон даатгалын хохирлын үнэлгээний үйл ажиллагааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах;
- 2.2.6. Хэвлэл мэдээллээр даатгалын хохирлын үнэлгээний үйл ажиллагааг нийтэд таниулах, гишүүн байгууллагуудыг сурталчилах;
- 2.2.7. Мэргэжлийн ном, сэтгүүл хэвлэн нийтлүүлэх;
- 2.2.8. Хөрөнгийн болон даатгалын хохирлын үнэлгээний чиглэлээр олон улсын нэр хүндтэй байгууллагуудтай түншлэх, гишүүнээр элсэх, хамтран ажиллах;
- 2.2.9. Гишүүдийн бүртгэл, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

3 дугаар зүйл. Холбооны үйл ажиллагаа, түүнд баримтлах зарчим

- 3.1. Холбоо нь дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах гурван хүрээг хамарсан үйл ажиллагааг явуулна:
 - 3.1.1. “Хөрөнгийн үнэлгээний тухай хууль”-ийн 3.1.3-д заасан зүйлийн үнэлгээ, түүнд учирсан хохирлын үнэлгээ;
 - 3.1.2. Хүний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын үнэлгээ;
 - 3.1.3. Гамшгийн үнэлгээ
- 3.2. Холбоо нь үйл ажиллагаандаа хүний эрх, эрх чөлөө, тэгш эрхийг эрхэмлэх, аливаа нам, улс төр, шашны үйл ажиллагаанаас ангид байх, хараат бус, бие даасан хэлбэрээр ил тод, нээлттэй үйл ажиллагаагаа явуулах, ардчилсан зарчмаар асуудлыг шийдэх, шийдвэрийг нийтээр дагаж мөрдөх зарчмыг баримтална.
- 3.3. Холбоо нь бүх гишүүддээ эрх тэгш үйлчлэх бөгөөд үйл ажиллагаандаа нийт гишүүдийн оролцоог хангаж ажиллахыг эрмэлзэнэ.

4 дүгээр зүйл. Холбооны гишүүнчлэл

- 4.1. Холбооны дүрмийг зөвшөөрсөн хөрөнгө болон даатгалын хохирол үнэлэгч компани, тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгийн үнэлгээчин холбооны гишүүн байж болно.
- 4.2. Хөрөнгийн болон даатгалын хохирол үнэлгээний компани, хувь хүн гишүүнээр элсэх өргөдлөө холбоонд бичгээр гаргана. Холбооны удирдах зөвлөл тухайн этгээдийн гишүүнчлэлийн асуудлаар хуралдаж шийдвэр гарган батламж, үнэмлэх олгох бөгөөд ингэхдээ хохирол үнэлэгч байгууллага, мэргэшсэн үнэлгээчдийг мэргэжлийн хариуцлагын даатгалд заавал даатгуулсан байхыг шаардана.
- 4.3. Холбоо нь дэмжигч гишүүнтэй байж болох бөгөөд тэдгээр нь холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор холбооноос зохион байгуулж байгаа олон нийтийн ажилд хамрагдахаас бусад холбооны дотоод үйл ажиллагаанд оролцохгүй.
- 4.4. Холбооны гишүүн дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
 - 4.4.1. Холбооны үйл ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцох;
 - 4.4.2. Холбооны удирдлага, бусад албан тушаалд өөрийн болон бусдын нэрийг дэвшүүлэх, сонгох, сонгогдох, томилогдон ажиллах, хуульд заасан үндэслэлээр болон өөрийн хүсэлтээр ажиллахаас татгалзах;
 - 4.4.3. Холбооны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, бусад шийдвэрийн төсөл санаачлах;
 - 4.4.4. Холбооны үйл ажиллагааны талаар санал хүсэлтээ илэрхийлэх, гомдол гаргах, шийдвэрлүүлэх;
 - 4.4.5. Эрхээ хамгаалуулах асуудлаар холбоонд хандан санал хүсэлт гаргах, холбоог үүргээ гүйцэтгэх талаар шаардлага тавих;
 - 4.4.6. Хөрөнгийн болон даатгалын хоиролын үнэлгээний тухай хууль тогтоомжид нийцүүлж холбооноос гаргасан дүрэм, журам, аргачлал, зөвлөмжийг дагаж мөрдөх;
 - 4.4.7. Холбоог санхүүгийн талаар дэмжиж, гишүүний татвараа цаг хугацаанд нь төлөх;
 - 4.4.8. Холбооны үйл ажиллагаанд оролцох, холбооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;
 - 4.4.9. Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас холбоонд учруулсан хохирлыг нөхөн төлөх;
 - 4.4.10. Холбооны гишүүнээс гарах, эргэж орох;
 - 4.4.11. Судалгааны зорилготой мэдээ, мэдээллийг шаардлагатай хэлбэрээр Холбоонд ирүүлэх;
 - 4.4.12. Хууль тогтоомж, холбогдох эрхийн актаар олгогдсон болон хүлээлгэсэн бусад эрх, үүрэг.
- 4.5. Гишүүний эрх, үүрэг дараах тохиолдолд дуусгавар болно:
 - 4.5.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болсон;
 - 4.5.2. Компани дампуурсан, татан буугдсан;

4.5.3. Буруутай үйл ажиллагааны улмаас холбоонд бодит хохирол учруулсан нь тогтоогдсон.

4.6. Гишүүний эрхийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ:

4.6.1. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 23-р зүйлд зааснаар үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хариуцлага хүлээлгэсэн, 24-р зүйлд зааснаар тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосны улмаас 22-р зүйлд заасан мэргэшсэн үнэлгээчингүй болсон;

4.6.2. Хууль, энэ дүрэмд заасан бусад үндэслэлээр хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн;

4.6.3. Холбооны хяналт, ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Удирдах зөвлөлийн шийдвэр гарч тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох талаар зохих төрийн байгууллагад санал хүргүүлсэн.

5 дугаар зүйл. Холбооны бүтэц, зохион байгуулалт

5.1. Холбоо нь дараах бүтэцтэй байна:

5.1.1. Бүх гишүүдийн хурал / Холбооны ерөнхийлөгч, хүндэт ерөнхийлөгч /

5.1.2. Удирдах зөвлөл

5.1.3. Хяналтын зөвлөл

5.1.4. Гүйцэтгэх удирдлага /Ажлын алба/

5.1.5. Мэргэжлийн зөвлөл

5.1.6. Ёс зүйн зөвлөл

5.1.7. Сургалт, арга зүйн зөвлөл

5.2. Холбоо нь орон нутагт салбар, эсхүл төлөөлөгчтэй байх бөгөөд эдгээр нь даатгалын шуурхай албаны чиг үүргийг давхар хэрэгжүүлж болно.

6 дугаар зүйл. Бүх гишүүдийн хурал

6.1. Холбооны өөрөө удирдах ёсны эрх барих дээд байгууллага нь холбооны бүх гишүүдийн хурал /цаашид "Хурал" гэх/ байна.

6.2. Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.2.1. Холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

6.2.2. Холбооны ерөнхийлөгчийг (цаашид Ерөнхийлөгч гэх) сонгох, чөлөөлөх;

6.2.3. Холбооны хүндэт ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх.

6.2.4. Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;

6.2.5. Хяналтын болон ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батламжлах, чөлөөлөх;

6.2.6. Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг сонсох, зөвлөмж өгөх;

6.2.7. Бусад.

6.3. Ээлжит хурал 2 жилд нэг удаа хуралдах бөгөөд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хурлын товыг хурал эхлэхээс 7 хоногийн өмнө гишүүдэд зарлана.

- 6.4. Ээлжит хурлын хугацааг тухайн хурал хуралдсан хугацаанаас хойш тоолно.
- 6.5. Ээлжид 2 жилийн хурлаар удирдах зөвлөлийн гишүүдийн 40 хүртлэх хувийг өөрчилж болно.
- 6.6. Хурал бүх гишүүдийн олонхи оролцооноор хүчин төгөлдөр болно.
- 6.7. Хурлаас гарах шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Хуралд оролцож буй төлөөлөгчдийн олонхийн саналаар тогтоол хүчин төгөлдөр болно. Тогтоолд хурлын даргалагч болон тэргүүлэгчид гарын үсэг зурж, Холбооны тамгыг дарна.
- 6.8. Ээлжит бус хурлыг дараах тохиолдолд зарлан хуралдуулна:
- 6.8.1. Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;
 - 6.8.2. Холбооны ерөнхийлөгч ээлжит бус хурал зарласан;
 - 6.8.3. Холбооны нийт гишүүдийн 70 хувиас доошгүй нь ээлжит бус хурал хуралдуулахыг шаардаж баталгаажуулсан;
 - 6.8.4. Удирдах зөвлөлийн гишүүдийн 70-аас дээш хувь нь ээлжит бус хурал хуралдуулахаар санал гаргаж гарын үсэг зурсан.
- 6.9. Холбооны **хүндэт ерөнхийлөгч, ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүдийг** сонгох, чөлөөлөх санал хураалтыг нууц хэлбэрээр явуулах бөгөөд сонгох албан тушаалын тоотой тэнцүү тооны нэр дэвшигч дэвшсэн болон бусад хурлын үйл ажиллагааны санал хураалтыг илээр явуулж болно.

7 дугаар зүйл. Ерөнхийлөгч

- 7.1. Хохирол үнэлэгчдийн холбооны ерөнхийлөгч (цаашид “Ерөнхийлөгч” гэх) нь үнэлгээчдийн хувьд манлайлагч, үнэлгээчдийн нэр хүнд, ёс зүйн хувьд үлгэр дуурайлал үзүүлэгч, үнэлгээчдийг байр суурь, бодлогын хувьд илэрхийлэгч болохын хувьд дараах шаардлагыг хангасан байна:
- 7.1.1. Үнэлгээчдийн дунд хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэжилтний хувьд бүрэн танигдсан;
 - 7.1.2. Ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагын зөрчил гаргаж байгаагүй;
 - 7.1.3. Үнэлгээчний мэргэжлийн үйл ажиллагааг таваас доошгүй жил эрхэлсэн;
- 7.2. Хурлаас ерөнхийлөгчийг сонгож, чөлөөлөх бөгөөд түүний үйл ажиллагааны зардал, цалингийн хэмжээг удирдах зөвлөлөөс тогтооно.
- 7.3. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.
- 7.4. Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 7.4.1. Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах;
 - 7.4.2. Удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах
 - 7.4.3. Холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх, гэрээ, хэлэлцээр байгуулах;
 - 7.4.4. Удирдах зөвлөлийн ажил үүргийн хуваарийг хэлэлцүүлж батлуулах;
 - 7.4.5. Гүйцэтгэх захирлыг томилуулах саналыг удирдах зөвлөлд оруулан батлуулах;
 - 7.4.6. Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах.

7.5. Холбооны хүндэт ерөнхийлөгч нь гишүүдийн эв нэгдэл, тогтвортой ажиллагааг илэрхийлэгч байх бөгөөд хохирол үнэлэгчдийн холбооны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, холбооны тасралтгүй тогтвортой ажиллагаа, бодлогыг цаашид үргэлжлүүлэх боломжтой хүнийг бүх гишүүдийн хурлаар сонгож, чөлөөлнө.

8 дугаар зүйл. Удирдах зөвлөл

8.1. Холбооны Удирдах зөвлөл /цаашид "Удирдах зөвлөл" гэх/ нь бүх гишүүдийн хурал хоорондын үйл ажиллагааг удирдлагаар хангах, холбооны үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангах чиг үүрэг бүхий хамтын удирдлагыг хэрэгжүүлнэ.

8.2. Удирдах зөвлөл нь холбооны гишүүн байгууллага, хөрөнгийн үнэлгээчид, даатгагч, даатгуулагчийн төлөөллийг оролцуулсан 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд шинээр сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь чөлөөлөгдсөн гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

8.3. Удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг сонгоход дараах дарааллыг баримтална:

8.3.1. Ажлын алба Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх байгууллагаас саналыг урьдчилан албан бичгээр авч бүх гишүүдийн хуралд өргөн мэдүүлнэ;

8.3.2. Хурлын төлөөлөгчдийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүдээр сонгож батламжлана.

8.3.3. Холбооны ерөнхийлөгч нь удирдах зөвлөлийн дарга байна.

8.4. Холбооны Удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлж, энэ дүрмийн 8.3-т заасан дарааллыг баримтлан нөхөн сонгоно:

8.4.1. Эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

8.4.2. Үүрэгт ажлаасаа чөлөөлүүлэхийг хүсч, өөрөө өргөдөл гаргасан;

8.4.4. Гишүүний үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй гэж Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи шийдвэрлэсэн .

8.5. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

8.6. Удирдах зөвлөлийн ээлжит хуралдаан цаашид "Хуралдаан" гэх/-ыг улиралд нэгээс доошгүй удаа хийх бөгөөд хуралдааны товыг 3 хоногийн өмнө зарлана.

8.7. Удирдах зөвлөлийн гишүүдийн 1/3-ээс багагүй хувь нь шаардсанаар, эсхүл Гүйцэтгэх захирлын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн Удирдах зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

8.8. Хуралдааныг Холбооны Ерөнхийлөгч даргална. Ерөнхийлөгчийн эзгүй үед Удирдах зөвлөлийн гишүүдийн саналаар хуралдаан даргалагчийг сонгоно.

8.9. Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь оролцсон бол хуралдааныг хүчинтэйд тооцож, Хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана. Санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналыг үндэслэн шийдвэр гаргана.

- 8.9.1. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд оролцоогүй гишүүн бичгээр болон цахим хаягаар санал ирүүлбэл ирцэд тооцно
- 8.10. Удирдах зөвлөлийн гаргасан шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.
- 8.11. Удирдах зөвлөлийн хуралдааныг тэмдэглэлээр баталгаажуулж, тэмдэглэлд хуралдаанаар хэлэлцсэн асуудал, баталсан шийдвэр, нууц санал хураалтыг тоогоор, ил санал хураалтыг нэрээр гаргасан дүн, сонирхлын зөрчилтэй холбогдсон тайлбар, гарах шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбар зэргийг тэмдэглэнэ.
- 8.12. Удирдах зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд тоо, тооцоолол, огноо, дугаар, нэр зэрэг техникийн алдаатай гарсан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.
- 8.13. Шаардлагатай гэж үзвэл зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн үнэн зөвийн баталгаа болгож техник хэрэгсэл ашиглан дуу болон дүрс бичлэг хийж болно.
- 8.14. Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:
- 8.14.1. Холбооны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө болон Ажлын албаны бүтэц, орон тоо, төсвийг батлах;
 - 8.14.2. Холбооны Ажлын албаны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө болон төсвийн төслийг хэлэлцэж батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайланг хэлэлцэх;
 - 8.14.3. Холбооны гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх;
 - 8.14.4. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажлын хэсэг байгуулах;
 - 8.14.5. Шинээр гишүүн элсүүлэх асуудлыг шийдвэрлэх;
 - 8.14.6. Холбооны үйл ажиллагаагаар жил бүр Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороонд болон гишүүн байгууллагуудад тайлагнах ;
 - 8.14.7. Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Ёс зүйн зөвлөлийн гишүүнд олгох нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох;
 - 8.14.8. Хуульд заасан бусад эрх.

9 дүгээр зүйл. Хяналтын зөвлөл

- 9.1. Хяналтын зөвлөл нь дараах эрхийг эдэлнэ:
- 9.1.1. Холбооны эд хөрөнгийн ашиглалт, төсвийн зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих;
 - 9.1.2. Холбооны Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;
 - 9.1.3. Өргөдөл гомдлын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.
- 9.2. “Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ыг Удирдах зөвлөл батална.
- 9.3. Хяналтын зөвлөл нь гурваас дээш гишүүн байгууллагын төлөөллөөс бүрдсэн бүрэлдэхүүнтэй байна.
- 9.4. Хяналтын зөвлөлийн даргыг гишүүдийн дотроос олонхийн саналаар 2 жилийн хугацаагаар томилно.
- 9.5. Хяналтын зөвлөл нь ямагт холбооны эв нэгдлийг эрхэмлэн ажиллана.

10 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлага

- 10.1. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүргийг Холбооны Гүйцэтгэх захирал / цаашид "Гүйцэтгэх захирал" гэх/ хэрэгжүүлнэ.
- 10.2. Ажлын алба нь Холбооны дотоод ажил, Сургалт, арга зүйн зөвлөл, Мэргэжлийн зөвлөл гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулна.
- 10.3. Гүйцэтгэх захирал дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ
- 10.3.1. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, удирдлагаар хангах;
 - 10.3.2. Үнэлгээний сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;
 - 10.3.3. Хохирол үнэлгээний мэргэжилтэнг бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулан Санхүүгийн зохицуулах хороотой зөвшилцөж батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;
 - 10.3.4. Гишүүн байгууллага, мэргэшсэн үнэлгээчдийн хийсэн үнэлгээ, мэргэжлийн ур чадвар, ёс зүйн талаар гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч шинжээч томилон дүгнэлт гаргуулж холбогдох газар нь хүргүүлж шийдвэрлэх;
 - 10.3.5. Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, арга зүйг боловсронгуй болгох талаар төсөл, хөтөлбөр санаачилж, удирдлагаар хангах;
 - 10.3.6. Гишүүн байгууллага, түүний ажиллагсдын эрх ашиг, ажиллах нөхцөл, эрх зүйн орчны талаар төрийн байгууллагуудад асуудал оруулж шийдвэрлүүлэх;
 - 10.3.7. Гишүүн байгууллага, үнэлгээчин, үнэлгээний мэргэжилтэн, нийт ажиллагсдын хууль, стандартын мөрдөлт, ёс зүйн дүрмийн биелэлтийг сайжруулахтай холбоотой нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах;
 - 10.3.8. Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх шаардлагатай асуудлыг боловсруулж, хуралдааны бэлтгэлийг хангах;
 - 10.3.9. Гишүүдийн жил тутмын үйл ажиллагааны тайланг гаргуулан авч нэгтгэн судалгаа хийж, тэдний үйл ажиллагааны талаар үнэлэлт ,дүгнэлт өгөх;
 - 10.3.10. Үнэлгээний үйл ажиллагаанд нэгдсэн аргачлал боловсруулж мөрдүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэн гишүүдэд үйлчлэх;
 - 10.3.11. Гишүүн байгууллагын ажил, үйлчилгээний зах зээлийг тэлэх, шинэ бүтээгдэхүүн бий болгох санаачилга гарган хэрэгжүүлэх;
 - 10.3.12. Гишүүн байгууллагад ажиллагсадын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, гадаад, дотоодын сургалт хөтөлбөрт хамруулах, туршлага судлуулах, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;
 - 10.3.13. Холбооны өдөр тутмын мөнгөн болон мөнгө бус орлого зарлагын гүйлгээг удирдах, Удирдах зөвлөлөөс олгогдсон эрх хэмжээний хүрээнд батлагдсан төсвийг зарцуулах;
 - 10.3.14. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг жилээр гаргаж, Удирдах зөвлөлд танилцуулж байх;

10.3.15. Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд Холбоог дотоод, гадаадад төлөөлөх, өмч хөрөнгө захиран зарцуулах;

10.3.16. Удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлыг нь дүгнэж, шагнаж урамшуулах, хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага тооцох, ажлаас чөлөөлөх.

11 дүгээр зүйл. Мэргэжлийн зөвлөл

11.1. Мэргэжлийн зөвлөл нь үнэлгээчний мэргэжлийн алдаа гаргасан тухай маргааныг хянан удирдах зөвлөлд оруулан шийдвэрлэнэ.

11.2. Мэргэжлийн зөвлөл 3 болон түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд гүйцэтгэх захирлын нэр дэвшүүлсэн саналыг үндэслэн Удирдах зөвлөлөөс томилно.

11.3. Мэргэжлийн зөвлөл нь үнэлгээчний хууль, стандартын мөрдөлт, ур чадварын байдал, хөрөнгийн үнэлгээний тайланд дүгнэлт гаргана.

12 дугаар зүйл . Ёс зүйн зөвлөл

12.1. Ёс зүйн зөвлөл нь хөрөнгийн болон даатгалын хохирол үнэлэгч, мэргэшсэн үнэлгээчдийн ёс зүйн алдаа гаргасан тухай холбогдох этгээдээс бичгээр ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл , ёс зүйн дүрмийн биелэлтэд хяналт тавьж, зөрчлийг арилгах саналыг удирдах зөвлөлд оруулан хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

13 дугаар зүйл. Сургалт, арга зүйн зөвлөл

13.1. Сургалт арга зүйн зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13.1.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагаар батлуулсан хөтөлбөрийн дагуу үнэлгээчнийг сургах, давтан сургах ажлыг хариуцан зохион байгуулах;

13.1.2. Мэргэшсэн үнэлгээчин, хохирол үнэлэгчийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхтэй холбоотой судалгаа, шинжилгээний ажил хийх, уралдаан тэмцээнийг санаачлан зохион байгуулах;

13.1.3. Үнэлгээ хийхтэй холбоотой нэгдсэн аргачлал, зөвлөмж боловсруулж гишүүн байгууллагуудыг арга зүйгээр хангах.

13.2. Сургалт арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг холбооны удирдах зөвлөлөөр батална.

14 дүгээр зүйл. Зэрэг дэв олгох

14.1 Холбоо нь хөрөнгө болон хохирол үнэлэгчдэд мэргэшлийн зэрэг дэв олгоно,

14.2 Зэрэг дэв олгох журмыг холбооны удирдах зөвлөл батална.

15 дугаар зүйл. Холбооны санхүүжилт

- 15.1. Холбооны хөрөнгө гишүүний татвар, үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ.
- 15.2. Гишүүн өөрөө хүсвэл хурлаас тогтоосон хугацаанаас өмнө гишүүний татварыг урьдчилан төлж болно. Энэ тохиолдолд татварын хэмжээ нэмэгдвэл зөрүү тооцохгүй.
- 15.3. Татвар төлөх журам, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас татварын хөнгөлөлт үзүүлэх болон бусад асуудлыг Удирдах зөвлөл шийдвэрлэх бөгөөд тодорхой гишүүнд давуу байдал олгохгүй байх зарчмыг баримтална.
- 15.4. Гишүүн байгууллага сар тутам 50 000 төгрөг, салбар 10,000 төгрөг, гишүүн хөрөнгийн үнэлгээчин жилд 100 000 төгрөгний татвар төлнө..
- 15.5. Хөрөнгө үнэлгээний тухай хууль болон холбооноос хохирлын үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх хариуцлага ноогдуулсан хугацаанд гишүүний татвараас чөлөөлөхгүй.

16 дугаар зүйл.Тайлан

- 16.1. Санхүүгийн тайланг зохих журмын дагуу гарган, холбогдох газруудад тушааж, татвар шимтгэлийн тооцоог хийж баталгаажуулна.
- 16.2. Холбооны ажлын албаны ажилд хяналт хийсэн тайлан болон санхүүгийн тайланд аудит хийсэн талаарх тайланг Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл бүх гишүүдийн хуралд танилцуулна.

17 дугаар зүйл. Шагнал, урамшуулал

- 17.1. Хөрөнгө болон хохирлын үнэлгээний үйл ажиллагааг хөгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, холбооны үйл ажиллагаанд идэвхи зүтгэлтэй ажиллаж амжилт гаргасан хөрөнгө болон хохирол үнэлгээний компани, хөрөнгийн үнэлгээчин, үнэлгээний мэргэжилтнүүдийг МХҮХ-ны нэрэмжит шагналаар шагнаана.
- 17.2. МХҮХ-ны нэрэмжит шагналын журам, болзолыг холбооны удирдах зөвлөл батална.

18 дугаар зүйл. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

Бүх гишүүдийн хурлын олонхийн саналаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

- 18.1.Дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг Мэргэжлийн зөвлөл болон гүйцэтгэх удирдлага боловсруулж, удирдах зөвлөлөөр хянуулсан байна.
- 18.2.Нэмэлт өөрчлөлтийг бүх гишүүдийн хурлын тогтоол гарснаар хүчин төгөлдөр болно.
- 18.3.Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг холбогдох байгууллагад ажлын 15 хоногийн дотор явуулах ажлыг гүйцэтгэх удирдлага хариуцна.

19 дүгээр зүйл. Бусад

19.1. Холбоог өөрчлөн байгуулах асуудлыг хурлаар нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

19.2. Эрх бүхий байгууллагаас Холбоог татан буулгах бол Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамтай зөвшилцөн татан буулгах комиссийг томилно.

19.3. Холбоог татан буулгах тохиолдолд түүний төлөх бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн хөрөнгийг татан буулгах комиссийн шийдвэрийн дагуу зарцуулна.

19.4. Холбоо нь өөрийн гишүүн болон Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, ажилтны хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн болон бусад хохирол, түүнээс үүсэх хариуцлагыг хүлээхгүй.

Хавсралт: 11 хуудастай